

“МОНОС ХҮНС” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 03 сарын 07-ны өдөр

№ 07/03
.....

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10, 59.11, 60 дугаар зүйл, 64 дүгээр зүйл, 65 дугаар зүйл, 67 дугаар зүйл, 71-р зүйл, 76-р зүйлийн 76.1.2, 76.1.3, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, Компанийн дүрмийн 6-р зүйлийн 6.4, 7.1.2 заалтууд болон 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монос хүнс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 04 сарын 23-ний Бямба гарагийн 11.00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж, Шангрила Улаанбаатар зочид буудлын 1 давхарт байрлах хурал-уулзалтын танхимд хуралдуулахаар зохион байгуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
 - 2.1. Компанийн 2021 оны санхүүгийн тайланд аудит хийсэн хөндлөнгийн компанийн аудитын дүгнэлтийг танилцуулах,
 - 2.2. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах,
 - 2.3. Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас гарсан тогтоолыг танилцуулах,
 - 2.4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны төсвийг батлах,
 - 2.5. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 03 сарын 31-ний өдрөөр тогтоож, “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг СЗХ, МХБ-д хууль тогтоомжид заасан хугацаанд хүргэсүгэй.
4. Компанийн хурлын зарыг тогтоолын Хавсралт №01-аар батлан, Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас, өдөр тутмын хоёроос доошгүй хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2022 оны 03 сарын 11-ны өдөр нийтэд мэдээлж, зарын давталтыг 2022 оны 03 сарын 25-ны өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлсүгэй.
5. Хурлаар хэлэлцэх асуудал, түүнтэй холбогдох баримт бичигтэй бүртгэлтэй брокер дилерийн компанидаа хандах, компанийн вэб хуудаст хандан танилцах боломжтой болохыг мэдээлсүгэй.
6. Хурлын саналын хуудсыг энэ тогтоолын Хавсралт №02-оор батлаж, брокер дилерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд тарааж, хуралд биечлэн оролцох

боломжгүй хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авах эцсийн хугацааг 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөр тасалбар болгосугай.

7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар ТУЗ-ийн гишүүн Б.Гантулгыг томилсугай.

8. Доорх нэр бүхий хүмүүсийг Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Хурал зохион байгуулах комиссын даргаар Үйл ажиллагаа хариуцсан захирал П.Тодрол
Хурал зохион байгуулах комиссын гишүүдээр:

Маркетингийн албаны дарга	Э.Энхтүвшин
Дижитал менежер	У.Цогтбилэг
Захирлын туслах	С.Гэрэлсүрэн
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	Н.Цагаанхүү
Дотоод аудитор	С.Отгонжаргал

9. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай.

Тооллогын комиссын даргаар санхүүгийн менежер Э.Амарболд

Тооллогын комиссын гишүүдээр бүтээгдэхүүний менежер Ц.Дөлгөөнмайдар
санхүүгийн шинжээч П.Энхбаяр

10. Хувьцаа эзэмшигчдийг хурлын материалтай танилцах нөхцөл, боломжийг бүрдүүлж, хуралд бэлтгэх, зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган ажиллахыг хурал зохион байгуулах комисс (П.Тодрол), Гүйцэтгэх захирал (А.Отгондарь) нарт даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Л.ХҮРЭЛБААТАР

2022 оны 03 сарын 07-ны өдрийн ТУЗ-ийн
хурлын *07/03* тогтоолын Хавсралт № 01



Өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгөх

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар

“Монос хүнс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Монос хүнс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж, Шангрила Улаанбаатар зочид буудлын 1 давхарт байрлах хурал-уулзалтын танхимд хуралдах бөгөөд хувьцаа эзэмшигч та бүхнийг идэвхтэй оролцохыг урьж байна.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр: 2022 оны 03 дугаар сарын 31

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2021 оны санхүүгийн тайланд аудит хийсэн хөндлөнгийн компанийн аудитын дүгнэлтийг танилцуулах,
2. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах,
3. Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас гарсан тогтоолыг танилцуулах,
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны төсвийг батлах,
5. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

Хурлаар хэлэлцэх асуудал, түүнтэй холбогдох баримт бичгийг бүртгэлтэй брокер дилерийн компанидаа хандах, компанийн вэб хуудаст хандан танилцах боломжтой.

Хурлын өдөр биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчид саналаа бүртгэлтэй брокер дилерийн компаниар дамжуулах, компанийн байранд биеэр ирж цаасаар өгөх боломжтой. Урьдчилан санал авах сүүлчийн хугацааг 2022 оны 04 сарын 15-ны өдрөөр тасалбар болгоно.

Хурлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг компанийн байранд болон хурал зохион байгуулах комиссын утсаар холбогдон авна уу.

Хаяг: Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, Мишээл экспо худалдааны төвийн баруун талд
Утас: 88080308, 99035178

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС



2022 оны 03 сарын 07-ны өдрийн ТУЗ-ийн хурлын 0103 тогтоолын Хавсралт № 02

МОНОС ХҮНС ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны тоо (ширхэг) : _____

Бүртгэсэн ҮЦК-ийн нэр: _____

Бүртгэсэн брокерийн овог, нэр: _____

№	Хурлаас гарах шийдвэрийн томъёолол	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	“Монос хүнс” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах			
2	“Монос хүнс” ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны төсвийг батлах			

Санал авах хуудсыг ашиглах санамж:

1. Хувьцаа эзэмшигч нь саналын хуудсыг бөглөхдөө санал өгөх хэсэгт (+) тэмдэглэгээ хийнэ. Жишээ нь: Зөвшөөрсөн бол зөвшөөрсөн гэсэн нүдэнд (+) тэмдэг гэхчилэн тавина.
2. Саналын хуудсыг балласан, засварласан, тэмдэглэгээ хийгээгүй бол хүчингүйд тооцно.
3. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол үнэт цаасны компани дээр очиж хурлын материалтай танилцан, саналын хуудсаа бөглөж 2022 оны 04 сарын 15 өдрөөс өмнө хүргүүлэх боломжтой.
4. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол тухайн төлөөлөх хүнд итгэмжлэл олгож нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____ / _____ / _____

Саналын хуудсыг хүчинтэй/ хүчингүйд тооцсон:

Хүчингүйд тооцсон бол шалтгаан: _____

Тооллогын комиссын дарга: _____

Гишүүд: _____

МОНОС ХҮНС
ХК

**МОНОС ХҮНС ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
САНАЛ АВАХ ХУУДАС /2/**

Хувьцаа эзэмшигчийн овог нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны тоо (ширхэг) : _____

Бүртгэсэн ҮЦК-ийн нэр: _____

Бүртгэсэн брокерийн овог, нэр: _____

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
1 ОВОГТОЙ	
2 ОВОГТОЙ	
3 ОВОГТОЙ	
4 ОВОГТОЙ	
5 ОВОГТОЙ	
6 ОВОГТОЙ	
№	ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	
1 ОВОГТОЙ	
2 ОВОГТОЙ	
3 ОВОГТОЙ	

Санал авах хуудсыг ашиглах санамж:

1. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол үнэт цаасны компани дээр очиж хурлын материалтай танилцан, саналын хуудсаа бөглөж 2022 оны 04 сарын 15 өдрөөс өмнө хүргүүлэх боломжтой.
2. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол тухайн төлөөлөх хүнд итгэмжлэл олгож нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.
3. Саналын хуудсыг балласан, засварласан бол хүчингүйд тооцно.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____ / / _____

Саналын хуудсыг хүчинтэй/ хүчингүйд тооцсон:

Хүчингүйд тооцсон бол шалтгаан: _____

Тооллогын комиссын дарга: _____

Гишүүд: _____

СЗХ-ны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн
377-р тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа
эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын нэгдүгээр хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	МОНОС ХҮНС ХК
Хаяг:	ХУД, Чингисийн өргөн чөлөө, 205/2 тоот
Хурал хуралдах өдөр, цаг:	2022 оны 04 сарын 23, 11:00 цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж, Шангила Улаанбаатар зочид буудлын 1 давхарт байрлах хурал-уулзалтын танхимд
Хурлын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	ТУЗ
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2022 оны 03 сарын 07
Олон нийтэд зарлах огноо:	2022 оны 03 сарын 11
Бүртгэлийн өдөр:	2022 оны 03 сарын 31
Хурлын баримт бичгийг БДК-д хүргүүлэх огноо:	2022 оны 03 сарын 17
Хүргүүлсэн огноо:	2022 оны 03 сарын 17
Хурлын даргын нэр:	ТУЗ хараат бус гишүүн Б.Гантулга
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	Дарга Э.Амарболд Гишүүд Ц.Дөлгөөнмайдар, П.Энхбаяр
Баримт бичгийн жагсаалт	1. Монос хүнс ХК-ийн ХЭ-ийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн 2022-03-07 өдрийн тогтоол 2. ХЭ-ийн хурлын зарын загвар 3. Монос хүнс ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны тайлан 4. Монос хүнс ХК-ийн 2021 оны санхүүгийн аудитлагдсан тайлан 5. Монос хүнс ХК-ийн ТУЗ гишүүдийн танилцуулга 6. Компанийн ТУЗ-ийн 2022 оны төсвийн санал 7. Компанийн болон бүтээгдэхүүний танилцуулга /товхимол/ 8. ХЭ-ийн хурлын дэг 9. ХЭ-ийн хурлын саналын хуудас 10. ХЭ-ийн хурлаас гарах шийдвэрийн төсөл
Баримт бичгийн хуудасны тоо:6..... хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА



(Handwritten signature)

/П.ТОДРОЛ/

_____ оны _____ сарын _____ өдөр